

СЗХ-ны 2018 оны 12-р сарын 4-ний өдрийн 377 тогтоолоор
баталсан "Хувьцаат компанийн эзэмшигчдийн хурлын зар хүргэх
журам"-ын нэгдүгээр хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"Гермес Центр"ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, "Гермес Центр"ХК-ийн төв оффисын байр, холбогдох утас: 30-15-77, 99 08 85 71
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 04-р сарын 15-ны өдрийн 15 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/ :	Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, "Гермес Центр"ХК-ийн оффисын байрны 3-р давхарт байрлах хурлын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдуулах шийдвэр гаргасан огноо:	2022 оны 02-р сарын 16-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2022 оны 02-р сарын 21-ний өдөр, 2022 оны 03-р сарын 09-ний өдөр
Бүртгэлийн өдөр:	2022 оны 03-р сарын 10-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:	2022 оны 02-р сарын 21-ний өдөр
Хүргүүлсэн огноо:	2022 оны 02-р сарын 18-ны өдөр
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын дарга М.Батболд гишүүд О.Энхжаргал, Л.Оюунгэрэл
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолууд, бусад хавсралтуудын хамт
Баримт, бичгийн хуудасны тоо:ширхэг
хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

.....*О. Энхтуяа*...../О.Энхтуяа/

2022 оны 02-р сарын 18-ны өдөр



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 10 дугаар зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02-р сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. "Гермес центр" ХК-ийн 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашиг 506 557 197.45 сая төгрөгийн
 - 499 533 486.36 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар
 - 7 023 711.09 сая төгрөгийг компанийн цалин урамшуулал болон нөөцийн санд тус тус хуваарилсугай.
2. "Гермес центр" ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02-р сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 6 төгрөг 36 мөнгө /зургаан төгрөг гучин зургаан мөн/-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 03-р сарын 10-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны сүүлийн хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2022 оны 03-р сарын 15-ны өдрөөс эхлэн олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3-р заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01-р сарын 27-ны өдрийн 45 тоот тогтоолоор шинэчлэгдсэн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02-р сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 15-ны өдрийн 15:00 цагт компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах
 - 2.2 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
 - 2.3 Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтыг танилцуулах
 - 2.4 Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийг хэлэлцэн батлах тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 03-р сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2022 оны 02-р сарын 18-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг хавсралт 1-р баталж, 2022 оны 02-р сарын 21 болон 2022 оны 03-р сарын 9-ний өдрүүдэд тус тус Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2022 оны 02-р сарын 21-ний өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэнг томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Комиссын дарга: О.Энхтуяа, Нягтлан бодогч
Гишүүн: Д.Эрдэнэсүрэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга: М.Батболд, Компанийн ажилтан
Гишүүд: О.Энхжаргал, Компанийн ажилтан
Л.Оюунгэрэл, Компанийн ажилтан
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах саналын хуудсыг хавсралт 3-р баталж, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 04-р сарын 14-ний өдрийн 18:00 цаг хүртэл хүлээн авахыг тооллогын комисс /М.Батболд/-т үүрэг болгосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зар мэдээ болон бусад зардлыг компанийн үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргахыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.
12. Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол шийдвэртэй уялдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахыг хурлын дарга /Д.Оюунсүрэн/, хурал зохион байгуулах комисс /О.Энхтуяа/ нарт үүрэг болгосугай.
13. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗАРЛАХ ХЭВЛЭЛИЙН ЭХ

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр: “Гермес центр” ХК

Хаяг, утас: БГД, 25-р хороо, Нарны зам 20/1, өөрийн байр, оффисын 3 давхар, № 302 тоот, 301577

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг: 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн 15:00 цаг

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:
2022 оны 3-р сарын 10-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал :

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтыг танилцуулах
- Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийг хэлэлцэн батлах тухай

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Хувьцаа эзэмшигчид та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, диллерийн компани болон УБ хот, БГД, 25-р хороо, Нарны зам 20,20/1 хаягт орших “Гермес” худалдааны төвийн оффисын 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах:

- Комиссын дарга : О.Энхтуяа, утас 9909-4991, имэйл хаяг: enkhee.7777@yahoo.com
- Гишүүн : Д.Эрдэнэсүрэн, утас 9908-8571, имэйл хаяг: erdenesuren2213@gmail.com

Зар түгээх мэдээллийн хэрэгслүүдийн жагсаалт:

- Өдрийн сонин
- UBS телевиз
- Монголын хөрөнгийн биржийн сайт
- Өөрийн цахим сайт

Зар гаргах өдрүүд : 2022 оны 02-р сарын 21-ний өдөр, 2022 оны 03-р сарын 09-ний өдөр

Жич : Сонинд зарыг гаргахдаа аудитын дүгнэлт болон санхүүгийн хураангуй тайланг хавсаргана.

ГЕРМЕСЦЕНТР
ХК

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

1. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт
 - 1.1 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан
 - 1.2 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
 - 1.3 Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтын тухай
 - 1.4 Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийн тухай

2. Хувьцаа эзэмшигчид та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, диллерийн компани болон УБ хот, БГД, 25-р хороо, Нарны зам 20,20/1 хаягт орших “Гермес” худалдааны төвийн оффисын 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд 30-15-77 тоот утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.



ТУЗ-ийн 2022 оны 02-р сарын 16-ны өдрийн
4 тоот тогтоолын хавсралт 3

**"ГЕРМЕС ЦЕНТР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС**
(Хэлэлцэх асуудал)

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог :

Хувьцаа эзэмшигчийн нэр :

Регистрийн дугаар:

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Брокерийн компанийн нэр :

"Гермес Центр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 15-ны өдрийн 15:00 цагт
"Гермес Центр" ХК-ийн төв байранд болно.

Санал авах хуудас ашиглах санамж

Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь:

- 1 Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан эсвэл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.
- 2 Засварласан, балласан болон залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

- 3 Хувьцаа эзэмшигч та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харилцдаг брокер дилерийн компани болон "Гермес Центр" ХК-ийн оффисын байрны 3-р давхрын 302 тоот өрөөнд 2022 оны 04-р сарын 14-ний өдрийн 18:00 цагаас өмнө ирүүлнэ үү.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт			
2	Компанийн ТУЗ-ийн цалингийн төсвийг батлах тухай			

Хувьцаа эзэмшигч (Итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн гарын үсэг:/

Санал авах хуудас үйлдсэн 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга:/М.Батболд/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан: